



ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/82

Улиастай

Дайчилгааны бэлтгэл нөөцийн  
бүрэлдэхүүнтэй сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 29 дүгээр зүйлийн 29.2, Дайчилгааны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2002 оны “Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний тайван цагийн сургалт зохион байгуулах журам” батлах тухай 230 дугаар тогтоол, 2017 онд Батлан хамгаалахын сайдын аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ, Батлан хамгаалахын сайдын 2017 оны н/03 дугаар тушаал, ЗХЖШ-ын даргын 2017 оны н/22 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн I зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтын зардлыг Батлан хамгаалах яамны төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб /дэд хурандаа Г.Нэмэхбаяр/-т зөвшөөрсүгэй.

3. Сургалтыг батлагдсан төсөв, хөтөлбөрийн дагуу зохион байгуулалтын өндөр түвшинд явуулж, дүнг ирүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб /дэд хурандаа Г.Нэмэхбаяр/-т, сургалтад оролцох иргэдийг цаг хугацаанд нь бүрэн хамруулахыг сумдын Засаг дарга Улиастай /Б.Эрдэнэбаатар/, Нөмрөг /Н.Түмэндорж/, Идэр /Х.Баярмаа/, Тэлмэн О.Батчулуун/, Цагаанхайрхан /Ч.Батмөнх/, Алдархаан /А.Мөнхсайхан/-т тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Л.Лхамсүрэн/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАТСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 09 өдрийн А/82 захирамжийн хавсралт

ДАЙЧИЛГААНЫ БЭЛТГЭЛ НӨӨЦИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТ

Д/д	Мэргэжил	Хүний тоо	Сургалтын хугацаа	Сургалт зохион байгуулах газар	Хамрагдах сумд
Дайчилгааны бэлтгэл нөөцийн I зэргийн бэлтгэл үүрэгтэн					
1	Планшетчин	10	2016.05.22- 2016.05.31	Зэвсэгт хүчний 325 дугаар анги /Завхан/	Улиастай-12 Нөмрөг-4, Идэр-4, Цагаанхайрхан-4, Тэлмэн-4, Алдархаан-4
2	Радиотелеграфчин	10			
3	Цахилгаанчин	10			
Хамрагдах хүний тоо		30	Хамрагдах сумдын тоо		6

ДАЙЧИЛГААНЫ БЭЛТГЭЛ НӨӨЦИЙН I ЗЭРГИЙН БЭЛТГЭЛ ҮҮРЭГТНИЙ СУРГАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Сургалт	Хүний тоо	Байр хоол	Тээврийн зардал	Сургалтын зардал	Бусад	Нийт /мян.төг/
1	I зэргийн бэлтгэл үүрэгтэн	30	1800000	300000	75000	150000	2325000

ЦЭРГИЙН ШТАБ